



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 70.

Арвайхээр

Хөгжлийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.7, Соёлын тухай хуулийн 14.2.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 3/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны "Бүтээлч-Өвөрхангай" хөтөлбөрийн 2.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн хөгжимт драмын театрын "Хөгжлийн хөтөлбөр"-ийг нэгдүгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөгжимт драмын театрын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Тогтохсүрэн/, аймгийн Засаг даргын дэргэдэх Соёл, спорт, аялал жуулчлалын газрын дарга /Д.Түмэнжаргал/ нарт даалгасугай.

ДАРГА

Г. ГАНБОЛД

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг.Нийтлэг үндэслэл.

Орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага нь биеэ даасан соёлын томоохон байгууллага болохын хувьд өөрийн хөгжлийн чиг баримжааг зөв тодорхойлох нь зүйтэй бөгөөд Монгол хүний сэтгэлэгээ, төлөвшилд тохирсон, үндэсний шинжийг агуулсан өөрийн өнгө аяс бүхий мэргэжлийн урлагийн байгууллага нийгэмд үгүйлэгдэж байна.

Өнөөдөр урлагийн нэлээд олон чиглэл хувийн хэвшилд шилжин зар сурталчилгаа, реклам, хэвлэл мэдээллийн түрэмгийллээр хэт бизнесжсэн байдал газар авсан, нөгөө талаас үзэж, сонсох бүхий л орон зайгаар гадны орны /солонгос сериал/ болон бусад барууны урлаг хүч түрэн орж ирэн, даяаршлын нөлөөлөл газар авч монгол хүний сэтгэлэгээ төлөвшилд тохирсон, үндэсний шинжийг агуулсан өөрийн өнгө аяс бүхий мэргэжлийн урлагийн байгууллага нийгэмд үгүйлэгдэж байна.

Иргэд ч төвийн болон гадны үзвэр үйлчилгээг аван дадсаар өөрийн нутгийн театрыг хүлээн авах, хөгжих боломжийг хязгаарласаар театр ч тэр байдалдаа дасан зохицон эрч хүчгүй байдал бий болсон байна.

Соёл, урлагийн эрхзүйн орчин тааруу, залуу уран бүтээлчид тогтвортой суурьших боломж муу, чанартай уран бүтээл хийх төсөв хангалтгүй, уран бүтээл туурвилаа гэхэд маркетингийн бодлого дутмагаас үзэгчдэд танигдахгүй зэрэг бэрхшээлийн улмаас орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага амжилттай ахиж дэвших, төвийн мэргэжлийн урлагийн байгууллагатай өрсөлдөх боломж жил ирэх тусам багасч байна.

Орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагад төрөөс баримтлах соёл, урлагийн бодлоготой уялдсан, тогтсон чиг баримжаатай, өөрийн өнгө төрхтэй, чадварлаг, мэргэшсэн, орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулахуйц цогц, тогтвортой хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## **Соёр. Алсын хараа, эрхэм зорилго.**

### **Алсын хараа.**

Төв халхын өв соёлыг дэлхийн соёлтой жишиглэн хөгжүүлж, аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулахуйц өрсөлдөх чадвар бүхий мэргэжлийн урлагийн байгууллагыг хөгжүүлэхэд оршино.

### **Эрхэм зорилго.**

Төв халхын өв соёлыг хадгалсан, хүний хөгжлийг дэмжсэн, Өвөрхангай аймгийн нийгэм эдийн засагт тогтвортой үр ашигтай, өрсөлдөх чадвар бүхий төвийн бүсийн мэргэжлийн урлагийн байгууллагын төв болгон хөгжүүлнэ.

### **Гурав. Стратегийн зорилт, үр дүн, үйл ажиллагаа.**

**Стратегийн Зорилт 1.** Өндөр гэгээний өв соёлд тулгуурласан, түүнийг сурталчлах уран бүтээл болон “Төв халхын уртын дуу”-г тодотгох, уртын дуу оролцсон томоохон уран бүтээл, халх биелгээ бүжиг, драмын урлагаар өөрийн брэндийг бий болгох.

**Үр дүн:** Төв халхын уртын дууны өв санг хадгалсан, Брэнд уран бүтээлтэй болно.

### **Үйл ажиллагаа.**

1.1.1 МУГЖ Төв халхын алдарт уртын дуучин С.Сумъяагийн нэрэмжит аймгийн уралдааныг 2015, 2019 онуудад зохион байгуулан, Улсын чанартай уралдааныг 2017 онд зохион байгуулах, нутгийн онцлогтой уртын дууны аялгуу хэмнэл, өв санг хадгалж, хамгаалан үлдэх төсөл хэрэгжүүлнэ.

1.1.2 Өндөр гэгээнийг сурталчилсан, уртын дууг оролцуулсан, дуулалт бүжгийн жүжгийн “Занабазар” томоохон уран бүтээл туурвих төсөл хэрэгжүүлнэ.

**Стратегийн Зорилт 2.** Хөгжимт драмын театрын үйл ажиллагааны менежментийг сайжруулан, мэргэжлийн урлагийн байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх орчинг бий болгож, мэргэжлийн, мэргэшсэн чадварлаг уран бүтээлчдээр боловсон хүчнээ хангах, Улсын болон олон улсын хэмжээнд зохион байгуулагддаг томоохон уралдаан, наадмуудад тогтмол оролцох, амжилт үзүүлэх .

**Үр дүн:** ХДТ-ын боловсон хүчний хангалт сайжирч, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

### **Үйл ажиллагаа.**

2.1.1.Хөгжим драмын театрын үйл ажиллагааны менежментийг сайжруулахад чиглэсэн шат дараалсан төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

2.1.2.Боловсон хүчний хангалтыг 100 хувьд хүргэнэ.

2.1.4. Концертмейстр, найруулагч, хормейстр, балетмейстр зэрэг чухал орон тоон дээр орон нутгаас тодорхой урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллуулах “Өрсөлдөх чадварыг сайжруулах нь” хөтөлбөр, төсөл хэрэгжүүлнэ.

2.1.5 Уран бүтээлчдийн ажлын байрандаа өсөх боломжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор уран бүтээлийн дүрийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг зарчимд шилжинэ.

2.1.6 Байгууллага өөрөө санаачлан Төвийн бүсийн мэргэжлийн урлагийн байгууллагын уралдаан зохион байгуулна.

2.1.7 ХДТ-ын уран бүтээлчдийн тоог нэмэгдүүлнэ.

2.1.8 Орон нутаг СУИС-тай хамтран “Студи сургалт”- ыг ХДТ-т зохион байгуулна.

2.1.9 Дутагдалтай хөгжмийн зэмсгийн хангалтыг нэмэгдүүлнэ.

2.1.10 Уран бүтээлчдийн чансааг тодорхойлох Улсын болон, олон улсын чанартай мэргэжлийн уралдаан наадмуудад тогтмол оролцож, амжилт гаргана.

**Стратегийн Зорилт 3.** Театрын хөгжлийн чиглэл, үзэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлийн шаардлагад тохирсон уран сайхны бодлогыг хэрэгжүүлэх, уран сайхны мэргэшсэн зөвлөлийг ажиллуулах.

**Үр дүн:** Уран бүтээлийн чанар сайжирч, өрсөлдөх чадвар дээшилнэ.

3.1.1. ХДТ-ын уран сайхны зөвлөлийг 100 хувь мэргэжлийн болгох, мэргэшүүлэх, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн уран бүтээлийн эрэл хайгуулыг хийх чадвар бүхий нэгдмэл үйл ажиллагаатай, багаар ажиллах чадвартай бүрэлдэхүүнийг бий болгон ажиллуулна.

3.1.2. Хамтлагийн уран бүтээлийн тоглолтыг томоохон концертод тоглуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

3.1.3 Гадаадад уран бүтээлчдээ мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах, туршлага судлуулна.

3.1.4 БНХАУ болон бусад оронд аялан тоглолт зохион байгуулна.

3.1.5 Дэлхийн болон Үндэсний сонгодог бүтээлүүдийг мэргэжлийн өндөр түвшинд найруулан тавьж үзэгчдийн хүртээл болгоно.

3.1.6. Судалгааны эрэл хайгуулын тусгай байгууллагатай хамтран ажиллаж, Төв халх уран бүтээлийн төрөл жанарыг гаргаж ирнэ.

**Стратегийн Зорилт 4.** Уран сайхны зөвлөлтэй баг болж ажиллах чадвартай, орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн уран бүтээл, үзэгчдийн судалгааг хийдэг, зар сурталчилгааны өндөр менежменттэй үзэгчдэд уран бүтээлээ PR – дах чадвар бүхий Маркетингийн албатай болох.

**Үр дүн:** ХДТ-ын өрсөлдөх чадварт ахиц гарна.

4.1.1 Уран сайхны зөвлөлтэй ажлын уялдаа холбоо бүхий маркетингийн албаны хийх ажлын чиглэлийн талаарх туршлагыг судлан маркетингийн оновчтой тогтолцоотой болно.

4.1.2 Зар сурталчилгаа, реклам, PR-ын зардлыг шийдвэрлэнэ.

5.1.3 Маркетингийн албаны үйл ажиллагааг зах зээлийн зарчимд суурилан хөгжих эхлэлийг тавих, шаардлагатай боломж нөхцлөөр хангана.

**Стратегийн Зорилт 5.** Их хаадын өлгий нутгийг сурталчлах урлаг, соёлын эвент арга хэмжээгээр гадаад дотоодод мэргэжлийн урлагийн байгууллагынхаа байр суурийг бэхжүүлж, Өвөрхангай аймгийн жуулчны байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх.

**Үр дүн:** Соёл, урлагийн аялал жуулчлал хөгжинө.

5.1.1. Орон нутгийн эрх зүйн орчныг сайжруулан Аймгийн ИТХ-аар шийдвэр гаргуулна.

5.1.2.Төв халхын "Их хаадын өлгий нутагт" нэртэй соёл, урлагийн эвент арга хэмжээтэй болох, төв халхын урлагийг сурталчилсан фестиваль зохион байгуулж тогтмолжуулна.

5.1.3. Аялал жуулчлалтай хослуулан "Төв халхын уртын дууны наадам"-ыг ССАЖГ-тай хамтран зохион байгуулна.

5.1.4.Орон нутгийн хэмжээнд зохион байгуулагддаг аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдэд оролцоно.

**Стратегийн Зорилт 6:** Уран бүтээлчдийн нийгмийн асуудал, урамшууллын тогтолцоог сайжруулах.

**Үр дүн:** Уран бүтээлчдийн ажиллах нөхцөл сайжирна.

6.1.1.Уран бүтээлчдийн нийгмийн асуудлыг сайжруулах эрх зүйн орчинг бий болгоход холбогдох байгууллагад хүсэлт тавьж, шийдвэрлүүлнэ.

6.1.2. Уран бүтээлийн чанараар ур чадварын нэмэгдлийг олгох, уран бүтээлчийг бодитой үнэлэх

6.1.3.Уран бүтээлчдээ эрүүл мэндийн нарийвчилсан үзлэгт хамруулан, сувилалд хөнгөлттэй нөхцлөөр хамруулах

**Стратегийн Зорилт 7:** Хөгжимт драмын театрын уран бүтээл туурвих таатай орчинг бүрдүүлнэ.

**Үр дүн:** Мэргэжлийн урлагийн байгууллага хөгжих таатай орчин бүрдэнэ.

7.1.1. Хөгжимт драмын театрын уран бүтээл туурвих таатай орчинг бүрдүүлэх хөтөлбөрийг дэс дараатай хэрэгжүүлнэ.

**Дөрөв. Хугацаа, санхүүжилт.**

Өвөрхангай аймгийн хөгжлийн хөтөлбөрийг 2015-2020 онд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн санхүүжилтийг орон нутгийн төсөв, Улсын төсвийн хөрөнгө оруулалт, бусад хандивлагчдаас бүрдүүлнэ.

**Тав. Удирдлага, зохион байгуулалт**

5.1. ХДТ-ын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Аймгийн Хөгжимт Драмын Театр хариуцана.

2.ХДТ-ын хөгжлийн хөтөлбөрийн стратегийн зорилтыг хэрэгжүүлэх боломж нөхцлөөр хангах, дэмжлэг үзүүлэх, орон нутгийн бодлоготой уялдуулах үүргийг аймгийн Засаг даргын Тамгын Газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Соёл, спорт, аялал жуулчлалын газар хариуцана.

5.3. Хөгжлийн хөтөлбөрийн үйл ажиллагааны 1.1.2, 2.1.2, 2.1.4, 2.1.7, 2.1.8, 2.1.10, 3.1.4, 4.1.2, 5.1.1, 6.1.1 зорилтот заалтуудыг хэрэгжүүлэхэд ИТХ-тай "Тогтвортой хөгжил, хамтын ажиллагааны санамж бичиг" байгуулан ажиллана.

5.4. ХДТ-ын хөгжлийн хөтөлбөр нь орон нутгийн удирдлага, салбарын агентлагаас бүрдсэн "Хяналт, чиг үүргийн зөвлөл"-тэй байх ба хөтөлбөрийн хэрэгжилтийг чиглүүлэх, зөвлөх үүргийг гүйцэтгэнэ. Зөвлөл нь жилд нэг удаа хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэн цаашдын чиглэлд зөвлөх үүргийг гүйцэтгэн, хөтөлбөрт өөрчлөлт оруулж болно.

### **Зургаа. Шалгуур үзүүлэлт**

6. ХДТ-ын Хөгжлийн хөтөлбөрийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

6.1.Хөгжимт драмын театрын орчин нөхцлийг сайжруулахад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ

6.2. Мэргэжлийн уран бүтээлчдийн тоо, нарийн мэргэшсэн боловсон хүчин болон, залуу уран бүтээлчдэд олгосон дэмжлэг / хөрөнгийн хэмжээ/

6.3. Бүс, Улс, Олон улсын уралдаанд оролцож шагнал эзэлсэн уран бүтээл, уран бүтээлчийн амжилтаар

6.4. ХДТ-ын тайзнаа туурвисан Монголын болон дэлхийн сонгодог уран бүтээлийн тоо

6.5. Хөндлөнгийн байгууллага болон үзэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ

6.6. Соёл, урлагийн эвент арга хэмжээнд хамрагдаж байгаа гадаад, дотоодын жуулчдын тоо

---o0o---

**ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэхүйлажиллагаа	Хугацаа	Хариуцахбайгууллага	Хамтранажиллахбайгууллага	Шалгуурзүүлэлт	Үрдүн	Төсөв, Хаанаас	
<b>Зорилт 1.</b> Өндөр гэгээний өв соёлд тулгуурласан түүнийг сурталчлах уран бүтээл болон Төв халхын уртын дууг тодотгох, уртын дуу оролцсон томоохон уран бүтээл, халх биелгээ бүжиг, драмын урлагаар өөрийн брэндийг бий болгох.				<b>Үрдүн.</b> Төв халхын уртын дууны өв сан хадгалагдаж, Брэнд уран бүтээлтэй болно.				
1.1	МУГЖ Төв халхын алдарт уртын дуучин С.Сумъяагийн нэрэмжит аймгийн уралдааныг 2015, 2019 онуудад зохион байгуулан, Улсын чанартай уралдааныг 2017 онд зохион байгуулах, нутгийн онцлогтой уртын дууны аялгуу хэмнэл, өв санг хадгалж, хамгаалан үлдэх төсөл хэрэгжүүлэх	2015-2020	Аймгийн ЗДТГ ХДТ	Аймгийн ЗДТГ ХДТ, 21 аймаг, Өвөрхангай аймгийн 18 сумд	Төв халхын уртын дуучин С.Сумъяагийн нэрэмжит аймаг, улсын уралдаанд оролцогчдын тоо	Төв халхын уртын дууны өв сан хадгалагдана.	20 сая Орон нутгийн төсөв	
1.2	Өндөр гэгээнийг сурталчилсан, уртын дууг оролцуулсан, дуулалт бүжгийн жүжгийн "Занабазар" томоохон уран бүтээл туурвих төсөл хэрэгжүүлэх	2015	ССАЖЯ Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	ССАЖЯам, Аймгийн ХДТ	"Занабазар"- уран бүтээлд зарцуулсан хөрөнгө, мэргэжлийн шүүмжлэгчдийн үнэлэлт, үзэгчдийн сэтгэл ханамж	Брэнд уран бүтээлтэй болох	30 сая Орон нутгийн төсөв, 20 сая улсын төсөв, 20 сая төсөл хэрэгжүүлэх	
<b>Зорилт 2.</b> Хөгжим драмын театрын үйл ажиллагааны менежментийг сайжруулан мэргэжлийн урлагийн байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх орчинг бий болгож мэргэжлийн, мэргэшсэн чадварлаг уран бүтээлчдээр боловсон хүчнээр хангах, Улсын болон олон улсын хэмжээнд зохион байгуулагддаг томоохон уралдаан, наадмуудад тогтмол оролцох, амжилт үзүүлэх				<b>Үрдүн.</b> ХДТ-ын боловсон хүчний хангалт сайжирч, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.				
2.1	Хөгжим драмын театрын үйл ажиллагааны менежментийг сайжруулахад чиглэсэн шат дараалсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2015-2020	Орон нутаг ССАЖГ, ХДТ	ССАЖГазар, ХДТ театр	Үйл ажиллагааны ахицаар, бусад мэргэжлийн байгууллагуудын хөгжлийн индексийн харьцууллаар	ХДТ-ын менежмент жишиг хэмжээнд хүрнэ	-	
Боловсон хүчний хангалтыг 100 хувьд				Мэргэжлийн боловсон		Уран		

Хаасан:

20.....оны .....-р сарын .....-ны өдөр

*Овоорангай Асеев*  
аймаг, сумын нэр/

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2.2.	хүргэх	2015-2020	ХДТ	ССАЖГазарХД Театр	хүчний тоо, хангалтын хувь.	бүтээлчдийн ур чадвар сайжирна.	-
2.3.	Концертмейстр, найруулагч, хормейстр, балетмейстр зэрэг чухал орон тоон дээр орон нутгаас тодорхой урамшуулал нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллуулах	2015-2020	ССАЖЯ Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	ССАЖЯам, ХДТеатр, ССАЖ Газар	Сонгодог болон орчин үеийн уран бүтээлийн тоглолтын тоо, уран бүтээл, уран бүтээлчийн уралдаан, наадамд оролцсон чансаа Бүс, төв, олон улсад зохион байгуулсан тоглолтын тоо	ХДТ-ын өрсөлдөх чадвар дээшилнэ.	20 сая орон нутгийн төсөв, 19.2 сая улсын төсөв
2.4.	Уран бүтээлчдийг ажлын байрандаа өсөх боломжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор уран бүтээлийн дүрийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг зарчимд шилжих /гол дүрд шагнал нэмнэ. Цалингийн сангаар нэмэгдэнэ.	2015-2020	ССАЖЯ Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	ССАЖЯам, ССАЖГазар, ХДТеатр	Уран бүтээл, уран бүтээлчийн уралдаан, наадамд оролцсон чансаа	ХДТ-ын өрсөлдөх чадвар дээшилнэ.	-
2.5.	Байгууллага өөрөө санаачлан Төвийн бүсийн мэргэжлийн урлагийн байгууллагын уралдаан зохион байгуулах	2017-2020	ССАЖГ, Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	ССАЖЯам, ССАЖГазар, ХДТеатр, Төвийн бүсийн аймгууд	Уралдааны үр дүн, уралдаанд оролцогчдын тоо	ХДТ-н нэр хүнд өсч, дээшилнэ.	20 сая Орон нутаг, 15 сая улсын төсөв, 5 сая төсөл хэрэгжүүлэх, бусад
2.6.	ХДТ-ын уран бүтээлчдийн тоог нэмэгдүүлэх	2015-2020	Аймгийн ИТХ, ЗДТГ	ССАЖГазар, ИТХ, ЗДТГ	Уран бүтээлчдийн орон тоо	ХДТ-ын өрсөлдөх чадвар дээшилнэ.	100 сая орон нутгийн төсөв, 185,6 сая улсын төсөв
2.7.	Дутагдалтай хөгжмийн зэмсгийн хангалтыг нэмэгдүүлэх	2015-2020	ССАЖГ, Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	ССАЖЯам, ХДТеатр	Хөгжмийн зэмсэг худалдан авахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, тоо	Хөгжмийн зэмсгийн дуугаралт нэмэгдэнэ.	10 сая орон нутгийн төсөв, 20,7 сая улсын төсөв
2.8.	Уран бүтээлчдийн чансааг тодорхойлох Улсын болон, олон улсын чанартай мэргэжлийн уралдаан наадмуудад тогтмол оролцож, амжилт гаргах	2015-2020	Аймгийн ИТХ, ЗДТГ ССАЖГ	ИТХ, ЗДТГ, ССАЖГазар, ХДТ	Уралдаанд оролцсон байдал, Амжилт, бүтээл,	ХДТ-ын өрсөлдөх чадвар дээшилнэ.	100 сая орон нутгийн төсөв, 100 сая улсын төсөв, 62 сая төсөл



2.9.	СУИС-ийн студи сургалтыг зохион байгуулах	2017-2020	Аймгийн ИТХ, ЗДТГ ССАЖГ	ССАЖГазар, ХДТеатр, ЗДТГ, ИТХ	Сургалтын үр дүн, хамрагдах хүний тоо	Боловсон хүчний хангалт дээшилнэ.	160 сая орон нутгийн төсөв
<b>Зорилт 3.</b> Театрын хөгжлийн чиглэл, үзэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлийн шаардлагад тохирсон уран сайхны бодлогыг хэрэгжүүлэх, уран сайхны мэргэшсэн зөвлөлийг ажиллуулах				<b>Үр дүн.</b> Уран бүтээлийн чанар сайжирч, өрсөлдөх чадвар дээшилнэ.			
3.1.	ХДТ-ын уран сайхны зөвлөлийг 100 хувь мэргэжлийн болгох, мэргэшүүлэх, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн уран бүтээлийн эрэл хайгуулыг хийх чадвар бүхий нэгдмэл үйл ажиллагаатай, багаар ажиллах чадвартай бүрэлдэхүүнийг бий болгон ажиллуулах	2015-2020	ССАЖГ, ХДТ	ССАЖГазар, ХДТеатр	Мэргэжлийн боловсон хүчний хангалт	Үйл ажиллагааны чанар хүртээмж сайжирна.	2 сая орон нутгийн төсөв, 2 сая улсын төсөв, 1 сая төсөл хэрэгжүүлэх
3.2.	Дэлхийн болон Үндэсний сонгодог бүтээлүүдийг мэргэжлийн өндөр түвшинд найруулан тавьж үзэгчдийн хүртээл болгох	2015-2020	ССАЖГ, Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ Соёлын ажилтны холбоо	Соёл урлаг хөгжүүлэх сан, ХДТеатр	Хөндлөнгийн байгууллагын хийсэн, үзэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүн	Уран бүтээлийн чанар сайжирч, өрсөлдөх чадвар дээшилнэ.	123 сая орон нутгийн төсөв, 50 сая улсын төсөв, 50 сая төсөл хэрэгжүүлэх
3.3.	Судалгааны эрэл хайгуулын тусгай байгууллагатай хамтран ажиллаж, Төв халх уран бүтээлийн төрөл жанарыг гаргаж ирэх	2016-2020	ССАЖГ ХДТ	ССАЖГазар, ИТХ, ХДТ	Шинээр бий болсон төрөл, чанар, уран бүтээлийн тоо	Орон нутгийн Брэндтэй болох	5 сая орон нутгийн төсөв, 5 сая улсын төсөв
3.4.	Хамтлагийн уран бүтээлийн тоглолтыг томоохон концертод тоглуулах бодлогыг хэрэгжүүлэх	2015-2020	ССАЖГ ХДТ	ССАЖГ, ХДТ	Уран бүтээлийн чанар, иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа	Уран бүтээлийн чанар, үзэгчдийн таашаалд нийцнэ	1 сая орон нутгийн төсөв, 1 сая орон нутгийн төсөв, 1 сая төсөл
3.5.	Гадаадад уран бүтээлчдээ мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах, туршлага судлуулах	2015-2020	ССАЖГ, Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	ССАЖЯам, ССАЖГ, ХДТ	Гадаадад мэргэжил дээшлүүлсэн уран бүтээлчийн тоо, туршлага судалсан байдал	Мэргэжлийн ур чадвар дээшилнэ	50 сая орон нутгийн төсөв, 20 сая улсын төсөв, 30 сая төсөл
3.6.	БНХАУ болон бусад оронд аялан тоглолт зохион байгуулах	2015-2020	ССАЖГ, Соёл, урлаг хөгжүүлэх сан	ССАЖГ, ХДТ	Зохион байгуулсан тоглолтын тоо, чанар, үрдүн	Мэргэжлийн ур чадвар дээшилнэ.	50 сая орон нутгийн төсөв, 20 сая улсын

			ХДТ				төсөв, 30 сая төсөл	
<b>Зорилт 4.</b> Уран сайхны зөвлөлтэй баг болж ажиллах чадвартай, орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн уран бүтээл, үзэгчдийн судалгааг хийдэг, зар сурталчилгааны өндөр менежменттэй үзэгчдэд уран бүтээлээ PR – дах чадвар бүхий Маркетингийн албатай болох				<b>Үрдүн:</b> ХДТ-ын өрсөлдөх чадварт ахиц гарна.				
4.1.	Уран сайхны зөвлөлтэй ажлын уялдаа холбоо бүхий маркетингийн албаны хийх ажлын чиглэлийн талаарх туршлагыг судлан маркетингийн оновчтой тогтолцоотой болох	2015-2020	ССАЖГ, Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	ССАЖГ, ХДТ	Судалгааны дүгнэлт, маркетингийн тогтолцооны удирдамж, тайлан	ХДТ-ын хөгжил сайжирна.	4 сая орон нутгийн төсөв, 4 сая улсын төсөв, 2 сая төсөл хэрэгжүүлэх	
4.2.	Зар сурталчилгаа, реклам, PR-ын зардлыг шийдвэрлэх	2015-2020	ССАЖГ, Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	Соёл урлаг хөгжүүлэх сан, ССАЖГ, ХДТ	Зарын чанар, үрдүн, уран бүтээлийн борлуулалт	ХДТ-ын нэр хүнд өснө.	15 сая орон нутгийн төсөв, 10 сая улсын төсөв, 5 сая төсөл	
4.3.	Маркетингийн албаны үйл ажиллагааг зах зээлийн зарчимд суурилан хөгжих эхлэлийг тавих, шаардлагатай боломж нөхцлөөр хангах	2015-2020	ССАЖГ ХДТ	ССАЖГ ХДТ	Үйл ажиллагааны хөтөлбөр, үрдүн, тайлан	ХДТ-ын өрсөлдөх чадварт ахиц гарна.	-	
<b>Зорилт 5.</b> Их хаадын өлгий нутгийг сурталчлах урлаг, соёлын эвент арга хэмжээгээр гадаад дотоодод мэргэжлийн урлагийн байгууллагынхаа байр суурийг бэхжүүлж, Өвөрхангай аймгийн жуулчны байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх				<b>Үрдүн.</b> Соёл, урлагийн аялал жуулчлал хөгжинө.				
5.1.	Орон нутгийн эрхзүйн орчныг сайжруулан Аймгийн ИТХ-аар шийдвэр гаргуулах	2015-2020	ИТХ ССАЖГ ХДТ	ССАЖГазар, ИТХ, ХДТ	ИТХ-ын шийдвэр	Эрхзүйн ээлтэй орчин бүрдэнэ.	-	
5.2.	Төв халхын “Их хаадын өлгий нутаг” нэртэй соёл, урлагийн эвент арга хэмжээтэй болох, төв халхын урлагийг суратлчилсан фестиваль зохион байгуулж тогтмолжуулах	2015-2020	ССАЖЯ ССАЖГ, Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	ССАЖЯ ССАЖГ, Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	Шийдвэр, захирамж, эвент арга хэмжээ, фестивалийн чанар, үрдүн	Орон нутгийн брэндтэй болох	40 сая орон нутгийн төсөв, 30 сая улсын төсөв, 30 сая төсөл хэрэгжүүлэх	
5.3.	Аялал жуулчлалтай хослуулан “Төв халхын уртын дууны наадам”-ыг ССАЖГ-тай хамтран зохион байгуулах	2015-2020	ССАЖЯ, ССАЖГ ХДТ Эрдэнэ-Зуу	ССАЖЯ, ССАЖГ ХДТ Эрдэнэ-Зуу	Оролцоо, үр дүнгийн тайлан Соёл, урлагийн эвент арга хэмжээнд хамрагдсан жуулчдын тоо	Орон нутгийн урлагийн Брэндтэй болох	60 сая орон нутгийн төсөв, 25 улсын төсөв	
	Орон нутгийн хэмжээнд зохион байгуулагддаг аялал жуулчлалын эвент	2015-	ССАЖГазар	ССАЖГазар,	Соёл, урлагийн эвент арга хэмжээнд	Соёл, урлагийн	4 сая орон нутгийн төсөв,	

5.4.	арга хэмжээнүүдэд оролцох	2020		ХДТ	хамрагдсан жуулчдын тоо	аялал жуулчлал хөгжинө.	3 сая улсын төсөв, 3 сая төсөл хэрэгжүүлэх
5.5.	Их тайз төсөл хэрэгжүүлэх	2015-2020	ССАЖГазар	ССАЖГазар, ХДТ	Соёл, урлагийн аялал жуулчлалын арга хэмжээнд хамрагсдын тоо	Соёл, урлагийн аялал жуулчлал хөгжинө	30 сая орон нутгийн төсөв, 30 сая улсын төсөв, 35 сая төсөл хэрэгжүүлэх
<b>Зорилт 6.</b> Уран бүтээлчдийн нийгмийн асуудал, урамшууллын тогтолцоог сайжруулах				<b>Үрдүн.</b> Уран бүтээлчдийн ажиллах орчин нөхцөл сайжирна.			
6.1.	Уран бүтээлчдийн нийгмийн асуудлыг сайжруулах эрх зүйн орчинг бий болгоход холбогдох байгууллагад хүсэлт тавьж, шийдвэрлүүлэх	2015-2020	Аймгийн ИТХ, ЗДТГ	ИТХ,ЗДТГ, ССАЖГ,ХДТ	Эрхзүйн акт, шийдвэр	Эрхзүйн таатай орчин бүрдэнэ.	-
6.2.	Уран бүтээлийн чанараар ур чадварын нэмэгдлийг олгох, уран бүтээлчийг бодитой үнэлэх	2015-2020	Аймгийн ССАЖГ, ХДТ	ССАЖГ, ХДТ	Уран бүтээлчдэд олгосон урамшууллын хэмжээ	ХДТ-ын уран бүтээлийн чанарт ахиц гарна	-
6.3.	Уран бүтээлчдээ эрүүл мэндийн нарийвчилсан үзлэгт хамруулан, сувилалд хөнгөлөлттэй нөхцлөөр хамруулах	2015-2020	ССАЖЯ ССАЖГ, Соёл, урлаг хөгжүүлэх сан ХДТ	ССАЖГ, ССАЖЯам, ХДТ	Эрүүл мэндийн үзлэг, рашаан сувилалд хөнгөлөлттэй нөхцлөөр хамрагдсан уран бүтээлчийн тоо	Уран бүтээлчдийн ажиллах орчин нөхцөл сайжирна	20 сая орон нутгийн төсөв, 10 сая улсын төсөв
<b>Зорилт 7.</b> Хөгжимт драмын театрын уран бүтээл туурвих таатай орчинг бүрдүүлнэ.				<b>Үрдүн.</b> Уран бүтээлчдийн ажиллах нөхцөл сайжирна.			
7.1.	Хөгжимт драмын театрын уран бүтээл туурвих таатай орчинг бүрдүүлэх хөтөлбөрийг дэс дараатай хэрэгжүүлэх	2015-2020	ИТХ ССАЖГ ХДТ	ИТХ ССАЖГ ХДТ	Хөгжимт драмын театрын орчин нөхцлийг сайжруулахад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ	Уран бүтээл туурвих таатай орчин бүрдэнэ.	50 сая орон нутгийн төсөв, 50 сая улсын төсөв, 29 сая төсөл хэрэгжүүлэх
Нийт							1.827.500₮